



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/139

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагуудыг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг “Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр”-т тусган батлуулж, хэрэгжүүлэхийг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Ганцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080577



Эрүүл мэндийн сайдын  
2018 оны 04 сарын 09 ны  
өдрийн 113 дугаар тушаалын  
хавсралт

**Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур  
үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагууд**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	01/2018	5 жил	2018-02-07	2023-02-07
2.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	02/2018	4 жил	2017-12-16	2021-12-16
3.	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	03/2018	4 жил	2018-01-02	2022-01-02
4.	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв	04/2018	3 жил	2017-12-27	2020-12-27
5.	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв	05/2018	3 жил	2017-12-11	2020-12-11
6.	Шүд эрүү нүүрний төв	06/2018	1 жил	2017-12-01	2018-12-01
7.	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	07/2018	3 жил	2017-03-29	2020-03-29
8.	Булган аймгийн Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлэг	08/2018	3 жил	2017-04-08	2020-04-08
9.	Булган аймгийн Хутаг- Өндөр сумын сум дундын эмнэлэг	09/2018	4 жил	2017-10-30	2021-10-30
10.	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг	10/2018	3 жил	2017-10-19	2020-10-19
11.	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	11/2018	4 жил	2017-06-01	2021-06-01
12.	Хэнтий аймгийн Биндэр сумын сум дундын эмнэлэг	12/2018	2 жил	2017- 08-13	2019- 08-13